



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/143

Хэрлэн сум

Онцгой комиссын гишүүдийг ажиллах нөхцлийг хууль тогтоомжид нийцүүлэхэд зориулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 49 дүгээр зарлиг, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2021 оны А/167 дугаар тушаал, аймгийн онцгой комиссын даргын 2024 оны 8 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор аймгийн Онцгой комиссын гишүүдийг ажиллах нөхцлийг хууль тогтоомжид нийцүүлэхэд зориулж 2.100.000 (хоёр сая нэг зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Онцгой комиссын үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ